



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2017 оны 11 дүгээр сар


**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 30%-иар буюу 2,235 сая ам.доллараар өсч, 9,591 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 33%-иар буюу 1,410 сая ам.доллараар, импорт 27%-иар буюу 825 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1,782 сая ам.доллараар давснаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 585 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 11 сар			Өөрчлөлт			
	2014	2015	2016	2015/2014		2016/2015		2015	2016	2017	2016/2015		2017/2016	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,011	8,467	8,274	(2,544)	-23.1%	(192)	-2.3%	7,738	7,356	9,591	(382)	-5%	2,235	30.4%
Экспорт	5,774	4,669	4,916	(1,105)	-19.1%	247	5.3%	4,243	4,276	5,686	33	1%	1,410	33%
Импорт	5,237	3,798	3,358	(1,439)	-27.5%	(439)	-11.6%	3,495	3,080	3,905	(415)	-12%	825.1	27%
Тэнцэл	538	872	1,558	334		686	78.7%	748	1,197	1,782	448	60%	585	49%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 1,945 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 680 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 64% буюу 6,106 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12% буюу 1,172 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 40%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 38%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 9%-иар өссөн, харин өмнөх сараас 2%-иар буурснаар 1.65-д хүрлээ. Тайлант сард зэсийн үнэ өссөн хэдий ч хөрөнгө оруулалт болон хэрэглээний барааны импортын үнэ давж өссөнөөр худалдааны нөхцөл өмнөх сараас муудсан байна.

Экспорт 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 33%-иар буюу 1,410 сая ам.доллараар өсөв. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нь нийт экспортыг 32 нэгж хувиар, уул уурхайгаас бусад төрлийн экспорт нь нийт экспортыг 1 нэгж хувиар өсөхөд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 3.0 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь 2.3 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
<b>1. Уул уурхай</b>		<b>3,714</b>	<b>88%</b>	<b>3,666</b>	<b>86%</b>		<b>5,047</b>	<b>89%</b>		<b>(48)</b>	<b>-1%</b>	<b>-1%</b>	<b>1,381</b>	<b>38%</b>	<b>32%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,335	2,072	49%	1,440	1,497	35%	1,315	1,441	25%	(575)	-28%	-14%	(56)	-4%	-1%
1.2. Чулуун нүүрс	12,831	508	12%	22,019	772	18%	30,977	2,111	37%	264	52%	6%	1,339	173%	31%
1.3. Боловсруулаагүй нефть	7,386	360	8%	7,314	302	7%	6,940	341	6%	(58)	-16%	-1%	39	13%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	4,346	202	5%	5,903	234	5%	5,538	281	5%	32	16%	1%	47	20%	1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	9,474	357	8%	14,254	577	13%	13,211	541	10%	220	62%	5%	(36)	-6%	-1%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	84	102	2%	117	132	3%	109	165	3%	31	30%	1%	32	24%	1%
1.7. Жонш, лейцит, нефелинт	256	60	1%	227	54	1%	281	73	1%	(6)	-10%	0%	19	34%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4	27	1%	5	23	1%	6	34	1%	(4)	-15%	0%	11	47%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	2	13	0%	1	10	0%	1	8	0%	(4)	-26%	0%	(2)	-22%	0%
1.10. Мөнгө /тонн/	54	10	0%	89	37	1%	0	1	0%	27	1%	1%	(36)	-98%	-1%
1.11. Бусад	52	2	0%	98	27	1%	376	51	1%	25	1575%	1%	24	1%	1%
<b>2. Мал аж, ахуй</b>		<b>306</b>	<b>7%</b>	<b>293</b>	<b>7%</b>		<b>357</b>	<b>6%</b>		<b>(12)</b>	<b>-4%</b>	<b>0%</b>	<b>64</b>	<b>22%</b>	<b>1.5%</b>
2.1. Амьд мал, малын мах	4	11	0%	7	16	0%	23	44	1%	4	40%	0%	28	182%	1%
2.2. Арьс, шир	293	29	1%	144	20	0%	266	20	0%	(9)	-30%	0%	(1)	-3%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	8	0%	0	6	0%	0	6	0%	(2)	-30%	0%	0	7%	0%
2.4. Ноолуур	6	238	6%	7	229	5%	7	259	5%	(9)	-4%	0%	29	13%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	12	18	0%	15	21	0%	17	27	0%	2	13%	0%	6	28%	0%
2.6. Бусад	0	1	0%	0	2	0%	1	2	0%	1	188%	0%	1	38%	0%
<b>3. Газар тариалан</b>		<b>25</b>	<b>1%</b>	<b>19</b>	<b>0%</b>		<b>13</b>	<b>0%</b>		<b>(6)</b>	<b>-25%</b>	<b>0%</b>	<b>(5)</b>	<b>-29%</b>	<b>-0.1%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>		<b>197</b>	<b>5%</b>	<b>298</b>	<b>7%</b>		<b>268</b>	<b>5%</b>		<b>101</b>	<b>52%</b>	<b>2%</b>	<b>(30)</b>	<b>-10%</b>	<b>-0.7%</b>
4.1. Хүнс	3	18	0%	7	34	1%	18	72	1%	16	91%	0%	38	113%	1%
4.2. Ноолууран эдлэл	1	24	1%	1	24	1%	1	30	1%	0	1%	0%	6	27%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	9	0%	2	13	0%	3	15	0%	4	46%	0%	2	13%	0%
4.4. Уул уурхай	34	74	2%	28	79	2%	33	100	2%	5	7%	0%	21	27%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	3	0%	0	5	0%	0	1	0%	1	48%	0%	(4)	-81%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	63	1%	1	136	3%	2	44	1%	73	114%	2%	(92)	-68%	-2%
4.7. Бусад	176	6	0%	203	8	0%	300	6	0%	2	31%	0%	(2)	-22%	0%
<b>5. Бусад</b>		<b>2</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>0%</b>		<b>1</b>	<b>0%</b>		<b>(1)</b>	<b>-62%</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>2%</b>	<b>0.0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>4,243</b>		<b>4,276</b>			<b>5,686</b>			<b>33</b>	<b>1%</b>		<b>1,410</b>	<b>33%</b>	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2017 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>434.0</b>	<b>31%</b>	<b>947.3</b>	<b>69%</b>	<b>1,381</b>	<b>38%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(137.0)	246%	81.4	-146%	(55.6)	-4%
1.2. Чулуун нүүрс	610.5	46%	728.4	54%	1,339	173%
1.3. Боловсруулаагүй нефть	(18.4)	-47%	57.9	147%	39	13%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(18.5)	-39%	65.7	139%	47.2	20%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(42.7)	118%	6.5	-18%	(36.2)	-6%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(13.4)	-41%	45.7	141%	32.3	24%
1.7. Жонш, лейцит, нефелинт	13.9	75%	4.7	25%	18.6	34%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4.9	45%	5.9	55%	10.8	47%
1.11. Бусад	37.7	155%	(13.3)	-55%	24.4	0%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>61.4</b>	<b>96%</b>	<b>2.9</b>	<b>4%</b>	<b>64</b>	<b>22%</b>
2.2. Арьс, шир	9.0	-1728%	(9.6)	1828%	(0.5)	-3%
2.4. Ноолуур	17.0	58%	12.5	42%	29.4	13%
<b>3. Газар тариалан</b>	<b>(2.2)</b>	<b>40%</b>	<b>(3.3)</b>	<b>60%</b>	<b>(5.4)</b>	<b>-29%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>82.0</b>	<b>-273%</b>	<b>(111.9)</b>	<b>373%</b>	<b>(30)</b>	<b>-10%</b>
<b>5. Бусад</b>	<b>0.1</b>	<b>388%</b>	<b>(0.0)</b>	<b>-288%</b>	<b>0.0</b>	<b>2%</b>
<b>Нийт дүн</b>	<b>575</b>	<b>41%</b>	<b>835</b>	<b>59%</b>	<b>1,410</b>	<b>33%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2017 оны эхний 11 сард экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 575 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 835 сая ам.доллараар тус тус өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрсний экспортын биет хэмжээ, үнэ өссөнөөс шалтгаалж 1,381 сая ам.доллараар өссөн байна. Харин мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээний аль аль нь нэмэгдсэнээс шалтгаалж 64 сая ам.доллараар өсчээ. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөн хэдий ч үнэ буурсанаас шалтгаалж 30 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2017 оны 11 дүгээр сард 1,282 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4%-иар өссөн, харин өнгөрсөн сараас 0.1%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,827, 64 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 25%-иар өсч, төмрийн хүдэр 12%-иар буурсан бол, өнгөрсөн сараас зэс 0.3%-иар, төмрийн хүдэр 4%-иар тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 11 дүгээр сард 71 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 46%-иар өссөн бол өмнөх сараас 1%-иар буурлаа.

**Импорт 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 27%-иар буюу 825 сая ам.доллараар өссөн.** Импортын өсөлтийг ерөнхий ангилалаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 14 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгж хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний жин 3 нэгж хувиар өсчээ.

**Хүснэгт 5.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>1,002</b>	<b>29%</b>		<b>1,064</b>	<b>35%</b>		<b>1,166</b>	<b>30%</b>	<b>62</b>	<b>6%</b>	<b>2%</b>	<b>102</b>	<b>10%</b>	<b>3%</b>
Түргэн эдэлгээтэй	773	583	17%	762	590	19%	767	661	17%	7	1%	0%	71	12%	2%
Хүнс	341	403	12%	359	409	13%	353	459	12%	6	1%	0%	50	12%	2%
Эм, гариа	2	67	2%	2	83	3%	2	86	2%	16	24%	0%	3	4%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	430	114	3%	401	99	3%	412	117	3%	(14)	-13%	0%	18	18%	1%
Удаан эдэлгээтэй	161	419	12%	120	474	15%	190	505	13%	55	13%	2%	31	7%	1%
Гутал, хувцас, цүнх	43	46	1%	42	49	2%	61	57	1%	3	7%	0%	8	17%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба төвлөг	66	83	2%	23	88	3%	69	83	2%	4	5%	0%	(5)	-6%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	232	7%	1	280	9%	1	305	8%	48	21%	1%	25	9%	1%
Бусад удаан эдэлгээтэй бараа	51	58	2%	54	57	2%	59	60	2%	(1)	-2%	0%	3	6%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>		<b>1,345</b>	<b>38%</b>		<b>1,077</b>	<b>35%</b>		<b>1,510</b>	<b>39%</b>	<b>(268)</b>	<b>-20%</b>	<b>-8%</b>	<b>434</b>	<b>40%</b>	<b>14%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	17	693	20%	15	634	21%	24	948	24%	(59)	-8%	-2%	313	49%	10%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	106	3%	1	205	7%	1	298	8%	99	94%	3%	93	45%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	16	587	17%	14	429	14%	23	649	17%	(158)	-27%	-5%	220	51%	7%
Барилгын материал	1,608	451	13%	667	268	9%	571	406	10%	(183)	-41%	-5%	137	51%	4%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	74	200	6%	50	174	6%	55	156	4%	(27)	-13%	-1%	(17)	-10%	-1%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>		<b>468</b>	<b>13%</b>		<b>466</b>	<b>15%</b>		<b>500</b>	<b>13%</b>	<b>(2)</b>	<b>0%</b>	<b>0%</b>	<b>33</b>	<b>7%</b>	<b>1%</b>
Хүнсний орц	40	25	1%	187	52	2%	38	18	0%	26	104%	1%	(34)	-65%	-1%
Химийн бүтээгдэхүүн	114	81	2%	114	78	3%	168	97	2%	(3)	-4%	0%	20	26%	1%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	17	14	0%	25	17	1%	42	21	1%	3	21%	0%	4	21%	0%
Цахилгаан эрчим хүч	1	117	3%	1	111	4%	2	123	3%	(6)	-5%	0%	12	11%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	1	0%	1	1	0%	2	1	0%	(0)	-6%	0%	(0)	-30%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	708	229	7%	692	208	7%	769	240	6%	(21)	-9%	-1%	32	15%	1%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>		<b>1,042</b>	<b>650</b>	<b>19%</b>	<b>939</b>	<b>467</b>	<b>15%</b>	<b>1,266</b>	<b>722</b>	<b>(183)</b>	<b>-28%</b>	<b>-5%</b>	<b>255</b>	<b>55%</b>	<b>8%</b>
Дизель түлш	599	348	10%	486	222	7%	736	386	10%	(126)	-36%	-4%	164	74%	5%
АИ-92, АИ-95	325	209	6%	296	147	5%	331	196	5%	(62)	-30%	-2%	50	34%	2%
А-80 болон бусад	118	94	3%	157	99	3%	199	140	4%	5	5%	0%	41	42%	1%
<b>Бусад</b>		<b>19</b>	<b>29</b>	<b>1%</b>	<b>11</b>	<b>5</b>	<b>0%</b>	<b>145</b>	<b>7</b>	<b>0%</b>	<b>(24)</b>	<b>-1%</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>3,495</b>		<b>3,080</b>		<b>3,905</b>		<b>(415)</b>	<b>-12%</b>				<b>825</b>	<b>27%</b>	

<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 6.** Импортын өөрчлөлт, 2017 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>	<b>111.4</b>	<b>109%</b>	<b>(9.4)</b>	<b>-9%</b>	<b>102.0</b>	<b>10%</b>
Түргэн эдэлгээтэй	10.5	15%	60.5	85%	71.0	12%
Удаан эдэлгээтэй	101.0	326%	(70.0)	-226%	31.0	7%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>407.8</b>	<b>94%</b>	<b>25.8</b>	<b>6%</b>	<b>434</b>	<b>40%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	346.3	111%	(32.9)	-11%	313.4	49%
Барилгын материал	73.8	54%	63.6	46%	137.4	51%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(12.2)	71%	(5.0)	29%	(17.2)	-10%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>30.0</b>		<b>3.3</b>		<b>33.2</b>	<b>7%</b>
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>181.4</b>	<b>71%</b>	<b>73.6</b>	<b>29%</b>	<b>254.9</b>	<b>55%</b>
Дизель түлш	131.4	80%	32.7	20%	164.0	74%
АИ-92, АИ-95	20.7	42%	29.1	58%	49.8	34%
А-80 болон бусад	29.3	71%	11.7	29%	41.1	42%
<b>Бусад</b>	<b>6.2</b>	<b>460%</b>	<b>(4.9)</b>	<b>-360%</b>	<b>1.3</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>736.8</b>	<b>89%</b>	<b>88.3</b>	<b>11%</b>	<b>825</b>	<b>27%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд баатдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр импорт нь тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалаж 737 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 88 сая ам.доллараар тус тус өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 102 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 40%-иар өссөн нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 55%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2017 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1 хувиар буурч тонн тутамд 617 ам.долларт хүрэв.